

ХИЛИЙН ЦЭРГИЙН АР ТАЛ ХАНГАЛТ, НӨЛӨӨЛӨХ ХҮЧИН ЗҮЙЛС

Б.БАЛСАНДОРЖ

ДХИС-ийн Удирдлагын академийн магистрант, дэд хурандаа

В.ПҮРЭВБААСАН

ДХИС-ийн Хилийн албаны удирдлага, стратегийн профессорын багийн дэд профессор, доктор(Ph.D), хурандаа

Товч агуулга: Хилийн цэргийн ар талын хангалт, түүнд нөлөөлөх хүчин зүйлсийг судлан, цаашид анхаарах зарим санал дэвшүүлэхийг зорилго.

Түлхүүр үгс: Хилийн цэргийн ар тал хангалт, нөлөөлөх хүчин зүйл, анхаарах асуудал.

Оршил

Тухайн улс орны эдийн засгийн хөгжлийн түвшин, байгалийн баялаг, хүн амын тоо хэдий чинээ их байна цэргийг шинэ төрлийн зэвсэглэл техникээр болон бусад төрлийн материал хэрэгслээр хангах ахуй нөхцлийг сайжруулах бололцоо төдий чинээ их байдаг байна. Манай орны эдийн засгийн өнөөгийн байдал нь хилийн цэргийг хэвийн үйл ажиллагаагаа явуулах нөхцлийг бүрэн хангаж хараахан чадахгүй байна. Хүн төрөлхтний түүхэн хөгжлийн гол чиг хандлага зах зээлийн эдийн засгийн харилцаанд улс орон шилжих үйл явц үргэлжилсээр байна.

Үндсэн хэсэг

Төрийн хилийн бодлого, эдийн засгийн бодлогын харилцан шүтэлцээ нь нэг нь нөгөөдөө шууд нөлөөлдөггүй бөгөөд эдийн засгийн төв байгууллагуудаар дамжин хэрэгжинэ. Эдийн засгийн төв байгууллагууд хилийн цэргийн захиалгыг үндэслэн хангах ажиллагааг зохион байгуулдаг. Ингэхдээ тус орны эдийн засгийн нөөцийн байдал, хилийн хамгаалалтанд зайлшгүй шаардлагатай хэрэгцээ зэргийг тооцон үзэж улс орны эдийн засгийн төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлдэг. Энэ төлөвлөгөөнд хилийн цэргийг хэрэгцээт зүйлээр хангах, улсын хилийн халдашгүй

дархан байдлыг хангахтай холбогдсон урсгал зардлыг санхүүжүүлэх, нөөцийг хэрэглэгчдийн хооронд хувиарилах зэрэг асуудлуудыг тусгана.

Хилийн цэргийн ар талын хангалт гэдэг нь анги хорооны байлдааны бэлтгэл сургууль, соёл хүмүүжлийн ажил, байлдааны бэлэн байдлыг хангах зорилгоор захирагч, штабаас төлөвлөгөөтэйгээр хэрэгжүүлж байгаа зохион байгуулалтын цогцолбор арга хэмжээг хэлэх бөгөөд материал хэрэгслийг бэлтгэх, татан авах, хадгалалт, хамгаалалт, ашиглалт, эзэмшилтийг зохион байгуулах, бие бүрэлдэхүүний тусгай бэлтгэлийн сургалт зэргийг өөртөө багтаана.

Бид зарим үед ар талын хангалтыг материал хэрэгслийн хангалттай хольж хутгах явдал гарсаар байна. Материал хэрэгсэл гэдэг нь ангиудын хэрэгцээг хангахад шаардагдах бүх төрлийн зэвсэглэл, байлдааны ба тусгай зориулалтын болон бусад техник тоног төхөөрөмж, сум галт хэрэгсэл, шатахуун, тосолгооны материал тусгай шингэн хүнс, хувцас, инженер, холбоо, хими, орон сууцны эд хогшил, эм уусмал, ороох боох материал, мөнгөн хөрөнгийг хэлнэ.

Материал хэрэгслийн хангалт нь ар талын хангалтын нэг л үүрэг нь байдаг. Хилийн цэргийн ар талын хангалтын төрлүүдийг нэгийг нь

нөгөөгөөс салангид ойлгох, сөргүүлэн тавих нь ар талын хангалтын тогтолцоог алдагдуулахад хүргэдгийг анхаарах нь зүйтэй. Ар талын хангалтын төрлүүд нь өөр хоорондоо амин холбоотой бөгөөд нэг нь тасалдахад анги салбарын байлдааны бэлэн байдал алдагдаж хилчдийн ахуй, хангамж доройтон улмаар бие бүрэлдэхүүний санаа сэтгэл алдагдахад хүрдэг. Улс орон зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжиж бүхнийг мөнгөөр хэмжин хөдөлмөр таваар болж байгаа өнөөгийн нөхцөлд санхүүгийн хангалтын үүрэг өсч, хангалтын бусад төрлүүдийн эх булаг болж байна.

Улсын хил хамгаалалтын ар талын хангалтын тогтолцоо нь дор дурьдсан арга замаар хэрэгжинэ. Үүнд:

- Төвлөрсөн хангалтын журмаар;
- Орон нутгийн хангалтын журмаар;
- Холимог хангалтын журмаар тус тус хэрэгжинэ.

Төвлөрсөн хангалт гэдэг нь дээд шатны байгууллага нь доод шатны байгууллагын захиалгыг үндэслэн тухайн байгууллагын жилийн төсөвт нь тохируулан мэргэжлийн албадын гаргасан хувиараар шууд хийх хангалтыг хэлнэ.

Төвлөрсөн хангалтаар:

- Тухайн хорооны төсвийн санхүүжилт;
- Зэвсэг, галт хэрэгсэл;
- Хил хамгаалалтын болон байлдааны зориулалттай техник;
- Цэргийн албан хаагчдын дүрэмт хувцас;
- Автомашин, тусгай зориулалтын техник хэрэгсэл;
- Орон нутагт олдоц багатай хүнсний бүтээгдэхүүн, хүн, мал эмнэлэгийн эм тариа зэрэг болно.

Орон нутгийн хангалт гэдэг нь тухайн хилийн хороо жилийн

батлагдсан төсөвтөө багтаан оршиж буй, орон нутгийн аж ахуйн нэгжүүдтэй харилцан тохиролцож, аж ахуйн гэрээ байгуулсны үндсэн дээр хийгдэж байгаа хангалтуудыг хэлнэ. Энэ хангалт одоо 90 орчим хувийг эзэлж байна.

Орон нутгийн хангалтаар:

- Шатахуун тосолгооны материал, тусгай шингэн;
- Тулээ, нүүрс;
- Хүнсний бүтээгдэхүүн, хүн, малын эм тариа, ороох боох материал;
- Бичгийн болон ариун цэврийн материал;

Холимог хангалт гэдэг нь төвлөрсөн болон орон нутгийн хангалтаар зэрэг хийгдэх хангалтуудыг хэлнэ.

Холимог хангалтаар:

- Зарим нэрийн хүнсний бүтээгдэхүүн,
- Хүн, мал эмнэлэгийн эм тариа, ороох боох материал,
- Зарим нэрийн барилгын материалын хангалтыг тус тус хийнэ.

Хилийн цэргийн ар талын хангалт нь тодорхой объектод чиглэгдэн зохион байгуулагддаг бөгөөд түүнд гадаад, дотоод олон хүчин зүйл нөлөөлдөг.

Тэдгээрээс зайлшгүй харгалзан үзвэл зохих дараахь хүчин зүйлийн нөлөөллийг зөв тооцох шаардлагатай байдаг.

Жилд гэгээтэй болон харанхуй байх цагийн нөлөөлөл.

Хилийн хамгаалалтын онцлогтой уялдан ар талын хангалт нь хоногийн ямарч хугацаанд тасралтгүй зохион байгуулагдах ёстой.

Ус цаг уурын эрдэм шинжилгээний хүрээлэнгээс гаргасан судалгаагаар манай орны хувьд нэг жилийн 8760 цагийн 51,2 хувь нь буюу 4486 цаг нь өдрийн 48,8 хувь нь буюу 4274 цаг нь шөнийн цаг байдаг байна.

а) Өдрийн цаг

Өдрийн цаг нь ар талын хангалтанд дараах нөлөөллийг үзүүлдэг.

Зэрэг нөлөөлөл:

- Ар талын хангалт тогтоосон хугацаанд заасан маршрутаар хийгдэнэ;

- Зам харгуйг зөв сонгох боломжтой;

- Хамгийн дөт замыг сонгох боломжтой;

- Бүх төрлийн тээврийн хэрэгслийг (ердийн хөсөг, авто зам, төмөр зам, агаарын болон усан тээвэр) ашиглах бололцоог олгоно;

- Ар талын хангалтыг хийх явцад хилийн манааны (хянах манаа зэрэг) үүрэг гүйцэтгэх бололцоог бүрдүүлнэ.

Сөрөг нөлөөлөл:

- Орчин тойрон ил тод харагдуулдагаас анхаарал, болгоомж сарних;

- Өнгөлөн далдлах ажиллагаанд саад учруулна.

б/ Шөнийн цаг

Шөнийн цаг нь ар талын хангалтанд дараах нөлөөллийг үзүүлнэ.

Зэрэг нөлөөлөл:

- Үзэгдэх орчин хязгаарлагдмал байдгаас сонор сэрэмж, анхаарал болгоомжийг дээшлүүлдэг.

Сөрөг нөлөөлөл:

- Үзэгдэх орчин хязгаарлагдмал байдгаас зам харгуйг сонгоход түвэг учруулж төөрч болзошгүй байдаг;

- Ар талын хангалтанд бүх төрлийн тээврийн хэрэгслийг ашиглах боломжгүй;

- Дуу чимээ, гэрэл гэгээ алсаас сонсогдож үзэгддэг тул өнгөлөн далдлалтын арга хэмжээг хэрэгжүүлэхэд хүндрэл учирдаг.

Өдрийн болон шөнийн цагийн үр дүн (өгөөж)-ийн коэффициент нь:

өдөр- $X < 1.0$

шөнө- $X < 0.75$ байна.

Байгаль цаг уурын нөлөөлөл

Монгол улсын хил орчмын нутаг дэвсгэрийг дор дурдсан таван бүсэд хуваадаг байна.

- уулын бүс

- ой тайгат бүс

- талын бүс

- ойт хээрийн бүс

- говийн бүс гэж ангилдаг.

Хилийн отряднуудын 21,7хувь нь уулын бүсэд, 17,4 хувь нь ой тайгат уулын бүсэд, 21,7 хувь нь талын бүсэд, 8,7 хувь нь ойт хээрийн бүсэд, 30,5 хувь нь говийн бүсэд тус тус байрлаж байна. Эдгээр бүсүүд нь хилийн цэргийн ар талын хангалтанд шууд нөлөөллийг үзүүлдэг.

Ой тайгат болон уулын бүс нь цасан бүрхүүл хамгийн удаан (5 сар) тогтдог, галлагаатай байх хугацаа урт (8сар), 30 хэмээс доош хүйтэн өдөр сар гаруй байдаг зэрэг нь ар талын хангалтын бэлтгэлийг эртнээс хангахыг шаарддаг.

Ой тайгат болон уулын бүс нь ар талын хангалтанд дор дурдсан нөлөөллийг үзүүлдэг. Үүнд:

- Зам харгуй эрт хаагддаг, зарим газарт ердийн хөсгөөс өөр төрлийн тээврийн хэрэгсэлийн хөдөлгөөн хаагддаг.

- Цасан шуурга, хүйтрэлт үе үе явагддаг нь ар талын хангалтыг тасалдуулахад хүргэдэг.

Тал хээрийн бүс нь цасан бүрхүүл тогтох хугацаа харьцангуй богино, галлагааны улирал 8 сар үргэлжилдэг, тэр бүр зам харгуй хаагдах, хэт хүйтрэлт болдоггүй зэрэг нь ар талын хангалтанд таатай нөлөө үзүүлдэг.

Хэдий тийм боловч энэ бүсийн зарим хэсэгт өвлийн улиралд цас их унадаг, урин дулааны улиралд намаг, шалбааг элбэгшдэг нь ар талын хангалтыг зохион байгуулахад хүндрэл учруулдаг онцлогийг зайлшгүй тооцох шаардлагатай байдаг.

Говийн бүс нь цасан бүрхүүл хамгийн богино хугацаанд (40 хоног) тогтдог, хүйтрэх болон галлагааны

улирал харьцангуй богино (5сар) зэрэг тааламжтай байдал нь ар талын хангалтанд таатай нөлөө үзүүлдэг хэдий ч шороон шуурга шуурах өдрийн тоо бусад бүсээс харьцангуй олон, 11м/сек-ээс дээш хурдтай шуурдаг, урин дулааны улиралд 40 хэмээс ч дээш халуун өдөр олон тохиолддог зэрэг нь хангалтад зарим талаар хүндрэл учруулдаг.

Монгол улсын хил орчмын нутаг дэвсгэрийн бүсчлэлийн байдлыг бүхэлд нь авч үзвэл ар талын хангалтанд дараах бодит нөлөөллийг үзүүлж байна. Үүнд:

1. Уулын болон ой тайгат уулын бүс нь хувцас, тоног хэрэглэлийн эдэлгээний хугацааг богиносгож дулаацах байруудыг олноор шаардахын дээр шатахуун зарцуулалтын нормыг 15-20 хувиар ихэсгэнэ.

2. Тал, хээрийн бүс нь өвлийн улиралд шатахуун зарцуулалтын нормыг мөн 15-20 хувиар ихэсгэдгийн дээр дулаацах байрыг шаарддаг, түлш бэлтгэлд ихээхэн хөрөнгө шаардаж бэлтгэх хөдөлмөр зарцуулалтыг ихэсгэдэг байна.

Уулын, ой тайгат уулын болон тал, хээрийн бүс нь ойн ба хээрийн түймэр дэгдэх үндсэн объект болдог тул гал түймрээс урьдчилан сэргийлэх онцгой ажиллагааг шаардахаас гадна төмс, хүнсний ногооны хадгалалтын асуудлыг шийдвэрлэхэд ихээхэн зардал цаг хугацаа шаардахад хүргэдэг.

3. Говийн бүс нь түргэн мууддаг хүнсний бүтээгдэхүүний хадгалалтыг зохион байгуулахад ихээхэн хүндрэл учруулдгийн дээр шатахууны хэвийн хорогдлыг 1.2-1.5 хувиар ихэсгэдэг байна.

Нөгөө талаар хилчдийн ундны усны асуудлыг шийдвэрлэхэд түвэг учруулдаг.

Эрүүл ахуйн эрдэм шинжилгээний байгууллагын гаргасан судалгаагаар говийн бүсийн

усны бараг 73 хувь нь ундааны усны хэрэгцээнд тэнцдэггүй гэсэн дүгнэлт гарсан байна.

Дэд бүтцийн нөлөөлөл.

Хилийн цэргийн ар талын хангалтанд нөлөөлдөг хүчин зүйлүүдээс дэд бүтцийн үзүүлэх нөлөөлөл ихээхэн чухал үүрэг гүйцэтгэдэг.

Дэд бүтцэд:

- тухайн бүсийн үйлдвэрлэлийн хөпжил;
- замын сүлжээ;
- тээвэр, холбооны сүлжээний хөгжил;

- хүн ам, ажиллах хүчний байршил зэргийг хамааруулан ойлгодог байна.

Монгол улсын хил орчмын нутаг дэвсгэрт 14 аймаг, 57 сум (хавсралт №4-ийг үзнэ үү) оршдог бөгөөд эдгээрийн нутаг дэвсгэрт хилийн 23 отряд байрлаж байгаагийн 30 хувь нь аймгийн төвд байрлаж байна.

Хилийн бүсийн аймгуудад хүнсний үйлдвэр, худалдааны сүлжээ муугүй хөгжсөн нь хүнсний бүтээгдэхүүний хангалтыг орон нутгаас хийх бололцоотой байгаагийн дээр түлш, уналга, идэшний малыг орон нутгаас бэлтгэх нөхцлийг үндсэнд нь бүрдүүлж ар талын хангалтанд эерэг нөлөөллийг үзүүлж байна.

Эдгээр аймгуудын нутаг дэвсгэрийн замын сүлжээ нь ихэвчлэн ердийн зам харгуй байгаа нь материал хэрэгслийг бэлтгэх, татан авахад зохицож байгаа хэдий ч цаг агаарын зарим тааламжгүй байдал нь ар талын хангалтыг саатуулахад хүргэж болзошгүй байдаг.

Түүнчлэн хилийн бүсийн аймгуудын нутаг дэвсгэрт хүн ам сийрэг суурьшдаг нь үйлдвэрлэл үйлчилгээний хөгжилд таагүй нөлөө үзүүлж байдаг нь хилийн цэргийн ар талын хангалтанд тэр чинээгээрээ шууд нөлөөлж материал хэрэгслийг

татан авах зай хэмжээг уртасгах, цаг хугацааг сунжруулахад хүргэдэг байна.

Дүгнэлт

Хилийн цэргийн ар талын хангалтанд нөлөөлөх хүчин зүйлүүдийг зөв тодорхойлж чадсанаар дараахь үр дүнд хүрэх боломжтой. Үүнд:

а) Ар талын хангалт нь цаг агаарын болон цагийн байдлын ямар ч нөхцөлд тасралтгүй явагддаг үндсэн зарчмыг хангана;

б) Хангалтын нэгжүүдээс хангагдагч цэрэг, анги, байгууллагад материал хэрэгслийг хугацаанд бэлтгэх, татан авах, тээвэрлэн хүргэх бололцоог бүрдүүлнэ.

в) Ар талын хангалтыг зохион байгуулахад голлох үүрэг гүйцэтгэгч тээвэрлэлтийн асуудлыг зохион байгуулахад тус дөхөм үзүүлнэ;

г) Тухайн орон нутаг, хилийн бүсийн аймгуудын дэд бүтцийг судалснаар хангалтыг хамгийн ойр

зайнаас хамгийн хямд зардлаар зохион байгуулах бололцоог олгож бүх төрлийн материал хэрэгслийн хангалтын нөөцүүдийг цуваажуулан байгуулж байршуулах нөхцөл хангагдана.

Санал

Хилийн цэргийн ар талын хангалтыг зохион байгуулахдаа ар талын хангалтын онолд тулгуурлан, удирдлага зохион байгуулалтыг боловсронгуй болгох, энэ талаар судалгаа хийх;

Хилийн цэргийн ар тал хангалтад нөлөөлөх хүчин зүйлсийг тооцоолж, ар тал хангалтыг зохион байгуулж буй өнөөгийн байдлыг улам сайжруулахад анхаарах зэрэг болно.

Эх сурвалжийн жагсаалт

- Б.Лхагва. Хилийн цэргийн ар талын хангалтыг боловсронгуй болгох зарим асуудал. Уб., 2005.

- Б.Лхагва. Хилийн цэргийн ар талын хангалтын зарим асуудал. Уб., 2005.